

Үзүүлэлтүүд:


<p><b>ДНБ -1.7%</b> 2016 оны III-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр</p> <p>Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15 хувь, үйлчилгээний салбар 5 хувиар буурсан нь нөлөөлөв.</p>	<p>ГШХО 10-р сард <b>7.3 сая ам.доллар</b></p> <p>Цэвэр ГШХО 10-р сарын байдлаар 7.3 сая ам.доллар болж өмнөх сараас өссөн үзүүлэлттэй гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.2 сая ам.доллараар буурав.</p>	<p>Төсвийн алдагдал <b>-2677 тэрбум төгрөг</b></p> <p>Төсвийн орлого 5059 тэрбум төгрөг, зарлага 7736 тэрбум төгрөг болж тэнцэл (2677) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Инфляци <b>0.2%</b></p> <p>Өмнөх сараас 0.5 хувиар, оны эхнээс 0.4 хувь өсч өмнөх оны мөн үеэс 0.2 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээл <b>1152 тэрбум төгрөг</b></p> <p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 1.1 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 35.6 хувиар нэмэгдэж 1152 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 9% байна.</p>	<p>Валютын нөөц <b>1 тэрбум ам.доллар</b></p> <p>Монголбанкны валютын нөөц 10-р сард өмнөх оны мөн үеэс 26.2 хувь буюу 368 сая ам.доллараар буурч 1039 сая ам.доллар болов.</p>
--	--	--	---	---	---

<p><b>\$</b></p> <p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш <b>2434.32 ₮</b></p>	<p><b>Орон сууцны үнийн индекс</b> <b>1.008</b> Өмнөх сараас 0.3%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 5.5%-иар буурав.</p>	<p><b>Монголбанкны бодлогын хүү</b> <b>14%</b></p>
---	--	--

УИХ-ын чуулганы өнөөдрийн ээлжит хуралдаанаар нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн баталж арваннэгдүгээр сарын 26-ныг бүх нийтийн амралтын өдөр болгов.

**Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ**

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2014 он		2015 он		2016 оны 11-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	19.5	0.8	14.4	0.6	22.1	7.7
Төмрийн хүдэр	6.3	0.4	6.3	0.2	5.5	2.2
Зэсийн баяжмал	1.4	2.5	1.4	2.3	1.4	1.5
<b>Нийт</b>	<b>27</b>	<b>4</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>29</b>	<b>11</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


**ДНБ**

ДНБ 2016 оны 3-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 193.3 тэрбум төгрөгөөр буурч эдийн засгийн өсөлт 1.7 хувиар буурав. ДНБ-ий 1.7 хувиар буурахад аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15 хувь, үйлчилгээний салбар 5 хувиар буурсан нь нөлөөлөв.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 0.5%, зарлага 26.2% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2677 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1575.2 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 25.6 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.




**Валютын ханш**

Арваннэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 441 төгрөг буюу 22.1 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 126.5 төгрөг буюу 5.5 хувиар өсч 2434.32 төгрөгөөр сулрав.



**Инфляци**


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 11-р сард өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсч, өмнөх оны эцсээс 0.2 хувиар өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 11-р сард өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ 6 хувь болон боловсролын үйлчилгээ 2.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, Монголбанк

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 10-р сарын байдлаар 1039 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 4.9 хувь буюу 54 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 26.2 хувь буюу 368 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.



\* Эх сурвалж Монголбанк

**MSE-20 индекс**

2016 оны аравдугаар сард 46.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 3.2 сая үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 5.5 хувиар буурсан бол арилжсан үнэт цаас 3.4 дахин өсөв. ТОП-20 дундаж индекс 2016 оны арваннэгдүгээр сард 10849 нэгж болж, өмнөх сарынхаас 376, өмнөх оны мөн үеийнхээс 1899 нэгжээр буурчээ.



\*Монголын хөрөнгийн бирж

**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) мөнгө өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар, өнгөрсөн сараас 0.9 хувиар нэмэгдэж 11.6 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 8 хувиар нэмэгдсэн бол өмнөх сараас 4.7 хувиар буурч нийт мөнгөний 6.6 хувийг эзэлж байна.



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2016 оны 11-р сард 8.2 их наяд төгрөг болж өмнөх сараас 14.4 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар буурав. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 14.3 хувиар буюу 1034.1 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 4.1 хувиар буюу 105 тэрбум төгрөгөөр өсч, төгрөгийн хадгаламж 2.1 хувиар буюу 119.4 төгрөгөөр буурав.



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 11-р сард өмнөх сарынхаас 1.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 6.9 хувиар нэмэгдэж 12 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1152 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.1 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 35.6 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9% байна.



**Ипотекийн зээл**


2016 оны 11-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.7 хувь (29.3 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 16.6 хувь (566.6 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.9 их наяд төгрөгт хүрэв. Арваннэгдүгээр сард нийт 511 зээлдэгчид 29.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 88555-д хүрэв. 2016 оны арваннэгдүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.8 хувь нь төгрөгийн зээл, 0.2 хувь нь валютын зээл байна. Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон зээлийн хэмжээ дунджаар 60.3 сая төгрөг байна.



## Гадаад худалдаа

## Гадаад худалдаа

2016 оны арваннэгдүгээр сарын байдлаар нийт барааны эргэлт 7356 сая ам.доллар,үүнээс экспорт 4276 сая ам.доллар, импорт 3079 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 1197 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 4.9 хувиар буурч, экспортын хэмжээ 0.8 хувиар өссөн бол импортын хэмжээ 11.8 хувиар буурсан байна. Экспорт өмнөх оны мөн үеэс 33.7 (0.8%) сая ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 271.3 сая ам.доллар, үүнээс зэсийн баяжмал 573.6 сая ам.доллар, үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт 222.2 сая ам.доллар, нүүрсний экспорт 267.3 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



\* Эх сурвалж УСХ, Монголбанк

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2016 оны 10-р сард 7.3 сая ам.долларын эерэг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 28.2 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсад 20.2 сая ам.доллараар буурсан бол Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.7 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 8 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.




\* Эх сурвалж Монголбанк

## Монгол Улсын гадаад өр

### Гадаад өр

2016 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 23.7 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 1 хувь (53 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 1 хувь (335 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 20 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 10 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 34 хувийг бусад салбаруудын өр, 29 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



\* Эх сурвалж Монголбанк

## Сарын онцлох үйл явдал

### 11.3-4

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, ХБНГУ-ын Конрад Аденауэрын сан, Дундговь аймгийн засаг даргын тамгын газар, Монголын эдийн засгийн форум, Монголын бизнесийн зөвлөл болон МҮХАҮТ хамтран Дундговь аймгийн Мандалговь хотод “Төвийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган”-ыг 11 сарын 3,4-нд зохион байгууллаа. Чуулганд Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар, ИТХ, төрийн болон олон улсын байгууллагын 150 гаруй төлөөлөл оролцов.

### 11.18

Дээрхийн гэгээн XIV Далай лам ес дэх удаагаа Монголд айлчлав. Айлчлал 18-23-ны хооронд үргэлжилж сүсэгтэн олон, лам хуврагуудад ховор номын авшиг хүртээж, эрдэмтэн багш нартай “Оюун санаа ба амьдрал” хэлэлцүүлэг, уулзалт хийв.

### 11.21

Олон улсын үнэлгээний “Moody's” агентлагаас Монгол Улсын В3 зээлжих зэрэглэлийг бууруулж, САА1, тогтвортой хэмээн үнэлэв. Тус агентлагаас эдийн засгийн хүндрэл, валютын нөөц, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт зэрэг шалтгаан зээлжих зэрэглэлийг бууруулахад хүргэсэн. Тус зэрэглэл нь Монгол Улсын Засгийн газарт олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө шууд болон шууд бусаар хүлээсэн өр төлбөрүүдээ богино хугацаанд барагдуулах, мөн төлбөрийн тэнцлийн дарамтад орохоос сэргийлэх чадвар бага байгааг илтгэж буй аж. 2017 онд Монгол Улс 8 тэрбум ам.долларын өр барагдуулах нь дотоодын нийт бүтээгдэхүүний 7.5 хувьтай тэнцэхээр байна.